



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
БАЯНЦАГААН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2022 оны 09 сарын 26 өдөр

Дугаар 12

Баянбулаг

Хоршоог хөгжүүлэх сангаас олгох зээлийн  
тэргүүлэх чиглэл, дээд хэмээг  
шинэчлэн тогтоох тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.5, Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2022 оны А/243 дугаар тушаалын хавсралт, Аймгийн Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн А/124 тоот захирамжийг үндэслэн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит XI дүгээр хуралдаанаар ТОГТООХ нь:

1.Орон нутгийн түүхий эд, нөөц боломж давуу талд түшиглэсэн үйлдвэрлэл, үйлчилгээг нэмэгдүүлж орон нутагт тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд хөнгөлөлтэй зээлийн санхүүжилтийг оновчтой зохион байгуулж хоршоо, жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээг эрхлэгчдийг дэмжих зорилгоор.

1.1.Мал аж ахуйн гаралтай түүхий эдийн бэлтгэл нийлүүлэлтийн нэгдсэн тогтолцоо (Загвар хоршоо)

1.2.Газар тариалан.

1.3.Мал амьтны тэжээл, тариарлалт үйлдвэрлэл.

1.4.Арьс шир боловсруулах.

1.5.Мах махан бүтээгдэхүүн, дайвар бүтээгдэхүүн боловсруулах.

1.6.Экспортод чиглэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх .

1.7.Эрчимжсэн мал аж ахуй.

1.8.Бэлчээрийн мал аж ахуй.

1.9.Аялал жуучлал.

1.10.Орон нуугийн онцлогт брэнд бүтээгдэхүүн үйдвэрлэлтийн тэргүүлэх чиглэл гэж үзсүгэй.

2.Төсөлд олгох зээлийн дээд хэмжээг хоршоо, аж ахуй нэгжид 100.000.000 (Нэг зуун сая), иргэнд 20.000.000 ( Хорин сая) хүртлэх төгрөг байхаар тогтоосугай.

643803036

Энэ тогоол гарсантай холбогдуулан Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2022 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 07 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА  Б.НАМГАРРЕНЧИН

